



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 28 өдөр

Дугаар А/328

Булган сум

Санхүү нөөц, хангалтын
мэргэжлийн ангийг томилох тухай

Монгол улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2 дахь заалт, Шадар сайдын 2017 оны 75 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2023 оны 257 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, хор уршгийг арилгах арга хэмжээг зохион байгуулан ажиллах байнгын бус ажиллагаатай санхүү, нөөц, хангалтын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, бүтцийг 2 дугаар, төлөвлөгөөг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хууль, дүрэм, төлөвлөгөөний дагуу ажлыг зохион байгуулж, удирдлагаар хангаж ажиллахыг Санхүү нөөц, хангалтын мэргэжлийн анги (Д.Батцогт)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж батлагдсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн А/103 дугаар тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



БАРИУН-ЭРДЭНЭ

07 дугаар сарын 20-ны өдрийн 07 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



Санхүү, нөөц хангалтын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн

Дарга: Д.Батцогт (АЗДТГ-ын СТСХ-ийн дарга)
Нарийн бичиг: Б.Бумцэнд (АЗДТГ-ын СТСХ-ийн мэргэжилтэн)

Аюулгүй байдал хариуцсан ажилтан: Б.Баярцэнгэл (ОНӨГ-ын мэргэжилтэн)

Холбоо хариуцсан ажилтан: Г.Буянзаяа (АЗДТГ-ын СТСХ-ийн мэргэжилтэн)

Хангалт хариуцсан ажилтан: С.Цэдэнлхам (АЗДТГ-ын СТСХ-ийн мэргэжилтэн)

Нэг. Санхүү, нөөцийн бүлэг

- Бүлгийн ахлагч Б.Баттулга (СХДАА-ны дарга)
- Нягтлан бодогч О.Сайнзаяа (АЗДТГ-ын мэргэжилтэн)
- Нөөцийн нярав П.Булган (АЗДТГ-ын СТСХ-ийн мэргэжилтэн)
- Туслах ажилтан П.Азхишиг (СХДАА-ны аудитор)
- С.Оюумаа (ОНӨГ мэргэжилтэн)
- Б.Бямбасүрэн (ОНӨГ-ын мэргэжилтэн)
- Ж.Оюун (СХДАА-ны улсын байцаагч)

Хоёр. Хүнсний хангалтын бүлэг

- Бүлгийн ахлагч Ч.Оюун-Эрдэнэчимэг (АЗДТГ-ын ХОХБТХ-ийн мэргэжилтэн)
- Нярав М.Мөнхгэрэл (ХХААГ-ын улсын байцаагч)
- Бүлгийн ажилтан М.Бадам (СХЗХ-ийн мэргэжилтэн)
- Т.Золбоо (ХХААГ-ын улсын байцаагч)
- Д.Мөнхбаасан (ХХААГ-ын мэргэжилтэн)
- “Жавхлант гартаам” ХХК, “Миний сүлжээ”
- Туслах ажилтан ХХК С.Ариунбулаг (СХЗХ-ийн жолооч)
- Жолооч

Гурав. Орон байр, хувцас хангалтын бүлэг

- Бүлгийн ахлагч захирал Э.Түвшинмөнх (1 дүгээр сургуулийн)
- Нярав Г.Гантуяа (АЗДТГ-ын СТСХ-ийн мэргэжилтэн)
- Бүлгийн ажилтан Б.Оюунсүвд (ЭӨЦС-ийн захирал)
- Д.Баттуяа (Булганхангай МСҮТ захирал)
- Н.Пүрэвсайхан (ХАА МСҮТ захирал)
- Л.Ганчимэг (3-р сургуулийн захирал)
- Л.Наранбат (СДСургуулийн захирал)
- Жолооч

Дөрөв. Тээврийн бүлэг

- | | |
|-------------------|---|
| - Бүлгийн ахлагч | Т.Баттулга (ОНӨГ-ын дарга) |
| - Бүлгийн ажилтан | Д.Уламбаяр (ОНӨГ-ын ахлах мэргэжилтэн) |
| - Механикч | Б.Анхбаяр (СХДАА-ны улсын ахлах байцаагч) |
| - Жолооч | Б.Батболд (СХДАА-ны жолооч)
Г.Гантөмөр (ОНӨГ-ын жолооч)
Д.Батмөнх (Татварын хэлтсийн жолооч)
С.Бямба-Очир (СХДАА-ны аудитор) |

Тав. Шатахуун, хийн түлш хангалтын бүлэг


- | | |
|-------------------|--|
| - Бүлгийн ахлагч | О.Баянмөнх (Ник-1 ШТС эрхлэгч) |
| - Нярав | Ч.Баярбат (Магнай трейд ШТС эрхлэгч) |
| - Бүлгийн ажилтан | С.Ганцоож (Шунхлай ШТС эрхлэгч)
Н.Нарантуяа (Тэс ШТС эрхлэгч)
Д.Лхагважав (Тэс ШТС эрхлэгч)
Ш.Лхамцэен (Юнигаз ШТС эрхлэгч)
Ц.Оюун (Жаст Ойл ШТС эрхлэгч)
М.Хишигжаргал (НИК-2 ШТС эрхлэгч)
С.Оюунчимэг (Сод монгол ШТС эрхлэгч) |
| - Туслах ажилтан | ШТС-ын бүх ажилчид |

04

Аймгийн Засаг даргын 20... оны
... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт



Санхүү, нөөц хангалтын мэргэжлийн ангийн бүтэц





04
Аймгийн Засаг даргын 20... оны сарын... -ны өдрийн... дугаар захирамжийн 3 дугаар хавсралт

САНХҮҮ, НӨӨЦ ХАНГАЛТЫН МЭРГЭЖЛИЙН АНГИЙН ТАКТИКИЙН ТОДОТГОСОН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үндэслэл: Гамшгаас хамгаалах тухай хууль, Монгол Улсын Шадар сайдын 75 дугаар тушаалаар батлагдсан Мэргэжлийн ангийн дүрэм, 120 дугаар тушаалаар батлагдсан Заавар батлах тухай, аймгийн Засаг даргын 2022 оны А/257 дугаар захирамж

Зорилт: Болзошгүй гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн голомтод эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, нэрвэгдэгсдэд эмнэлгийн болон хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд санхүү болон нөөц хангалтын дэмжлэг үзүүлэх

Чиглэл: Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлтгэл, бэлэн байдлыг хангах чиглэлээр нөөц хөрөнгө бүрдүүлэх ажлыг зохион байгуулах, гамшиг, ослын үед шаардагдах төрөл бүрийн хангалтын нөөцийг бүрдүүлэх, голомтод ажиллаж байгаа мэргэжлийн анги, сайн дурынхныг шатах тослох материал, ус, хоол, хүнс, орон байр, дулаан хувцас, хэрэглэлээр хангах, тээврийн үйлчилгээ үзүүлэх

№	Үйл ажиллагааны чиглэл	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх байгууллага	Хариуцах ажилтан
1.	Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, удирдлагаар хангах, бүлгийн гишүүдийг сургалт, мэдээллээр хангах, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх, холбоо, зарлан мэдээллийн техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах, хохирлын үнэлгээг хийх, гамшгийн хор уршгийг арилгах ажиллагаанд ашиглагдах, техник, багаж, хэрэгсэл, шатах тослох материал, цэвэр ус, хоол хүнс, хувцас, бусад бараа материалын нөөцийн судалгаа гаргах, бүрдүүлэх, зориулалтын дагуу зарцуулах, нөхөн сэлбэх	Гашиг ослын үед ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгааг гаргаж, мэргэжлийн ангийн гишүүдэд Гамшгийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн талаар сургалт зохион байгуулж, аймгийн хэмжээнд орон байр, хувцас хэрэглэл, шатах тослох материал, хоол хүнсний нөөцийн судалгааг гаргаж, бүлгийн үйл ажиллагаанд чиглэл өгч, холбоо мэдээллийн техник хэрэгслийн бэлэн байдлыг хангаж ажиллана. Бусад алба мэргэжлийн ангид шаардлагатай байгаа хэрэглэгдэхүүний тооцоо судалгааг гаргаж, бараа материалаар хангах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулж,	Санхүү, нөөц хангалтын мэргэжлийн анги	Дарга Д.Батцогт, Орлогч Б.Бумцэнд

	Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах чиглэлээр нөөц хөрөнгө бүрдүүлэх ажлыг төлөвлөх, зохион байгуулах, хохирол, хэрэгцээний үнэлгээнд үндэслэн шаардлагатай мөнгөн хөрөнгө, зардлыг тооцох, шийдвэрлүүлэх, гамшиг, ослын үед шаардагдах төрөл бүрийн хангалтын нөөцийг холбогдох норм, стандартын дагуу бүрдүүлэх, хадгалах, хамгаалах, сэлгэх ажлыг зохион байгуулах, хүмүүнлэгийн тусламжийн мэргэжлийн ангитай хамтран нөөцийн бараа бүтээгдэхүүнийг хуваарилах ажлыг зохион байгуулах	Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардлагатай төсвийн тооцооллыг гаргаж, удирдлагуудад танилцуулах, гамшиг ослын үед гарсан хохирлын хэмжээг тодорхойлох, хохирлыг арилгахад шаардагдах төсөв, хөрөнгийн судалгааг гаргаж, шийдвэрлүүлэх, мөнгөн хөрөнгийн нөөц бүрдүүлэх, санхүүгийн үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах, хүмүүнлэгийн тусламжийн мэргэжлийн ангитай хамтран нөөцийн бараа бүтээгдэхүүнийг гамшигын голомтод хүргэж, гамшигт өртсөн иргэд болон гамшигын голомтод ажиллаж байгаа алба мэргэжлийн ангиуудад хуваарилах ажлыг зохион байгуулна.	Санхүү, нөөцийн бүлэг	Бүлгийн ахлагч Б.Баттулга
2.	Нэрвэгдэгсэд болон гамшиг, ослын голомтод ажиллаж байгаа мэргэжлийн анги, сайн дурынхныг ус, хоол, хүнсээр хангах	Аймгийн хэмжээнд өргөн хэрэглээний бараа, материалын судалгааг гаргаж, аж ахуй нэгжүүдтэй гэрээ байгуулж, татан оролцуулж, гамшигт нэрвэгдсэн иргэд болон гамшигын голомтод ажиллаж байгаа мэргэжлийн анги, сайн дурынхныг ус, хоол, хүнсээр хангах ажлыг аюулгүй ажиллагааны зааварчилгааны дагуу шуурхай зохион байгуулж ажиллана. Санхүү, нөөц хангалтын мэргэжлийн ангиас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүрд биелүүлж, бусад мэргэжлийн анги, бүлгүүд, сайн дурынхантай хамтран ажиллана.	Хүнсний хангалтын бүлэг	Бүлгийн ахлагч Ч.Оюун-Эрдэнэчимэг
3.	Гамшиг, ослын үед нэрвэгдэгсэд болон аврагч, аврах ажиллагаанд дэмжлэг үзүүлж байгаа иргэдийн хэрэгцээг тодорхойлж, орон байр, дулаан хувцас, хөнжил, гудас зэргээр хангах	Гамшиг, ослын үед нэрвэгдэгсэд болон аврах, эрэн хайх ажиллагаанд оролцож буй мэргэжлийн анги, сайн дурынхны хэрэгцээг тодорхойлж, орон байр, дулаан хувцас, хөнжил, гудас зэрэг материалын судалгааг гаргаж, хангах үйл ажиллагааг аюулгүй ажиллагааны зааварчилгааны дагуу зохион байгуулж, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай	Орон байр, хувцасны хангалтын бүлэг	Бүлгийн ахлагч Э.Түвшинмөнх
4.				

	<p>Нэрвэгдэгсдэд тусламжийн бараа материал тээвэрлэн хүргэх, гамшиг, ослын голомтоос хүн ам, эд хөрөнгө, түүх дурсгалын үнэт зүйлсийг нүүлгэн шилжүүлэх, бусад шаардлагатай тээврийн үйлчилгээ үзүүлэх</p>	<p>зохион байгуулж, бусад мэргэжлийн анги, бүлгүүд, сайн дурынхантай хамтран ажиллана. Аймгийн хэмжээнд авто тээврийн судалгааг гаргаж, тэдгээрийг дайчилж, гамшиг, ослын үед гамшигт нэрвэгдсэн ард иргэд болон гамшгийн голомтод ажиллаж байгаа мэргэжлийн анги, сайн дурынханд хүнс, бараа материалыг тээвэрлэн хүргэх, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангах, хүн ам, эд хөрөнгө, түүх дурсгалын үнэт зүйлсийг нүүлгэн шилжүүлэх ажлыг аюулгүй ажиллагааны зааварчилгааны дагуу зохион байгуулж, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай зохион байгуулж, бусад мэргэжлийн анги, бүлгүүд, сайн дурынхантай хамтран ажиллана. Тээврийн үйлчилгээ үзүүлэх тохиолдолд удирдлагаас өгсөн аюулгүй ажиллагааны зааварчилгаатай танилцаж, холбоо мэдээлэл хариуцсан, ажилтанд мэдэгдэж, тээврийн хэрэгслийн марк, дугаарыг хамгаалалтын албанд мэдээллийг хүргүүлж, аюулгүй байдлыг хангаж ажиллана.</p>	<p>Тээврийн бүлэг</p>	<p>Бүлгийн ахлагч Т.Баттулга</p>
<p>6.</p>	<p>Гамшиг, ослын үед үүрэг гүйцэтгэж байгаа автомашин, бусад техник хэрэгслийг шатах тослох материалаар цэнэглэх, хангах, нөөц бүрдүүлэх</p>	<p>Гамшиг, ослын үед үүрэг гүйцэтгэж байгаа авто машин техник хэрэгслийн тоог гаргаж, шатах тослох материалын нөөцийг бүрдүүлж, аюулгүй ажиллагааны зааварчилгааны дагуу зохион байгуулж, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай зохион байгуулж, бусад мэргэжлийн анги, бүлгүүд, сайн дурынхантай хамтран ажиллана.</p>	<p>Шатахуун хангалтын бүлэг</p>	<p>Бүлгийн ахлагч О.Баянмөнх</p>

---oO---